



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |      |  |            |      |
|------|--|------------|------|
| 347. | Төрийн захиргааны зарим албан хаагчид албан тушаалын зэрэг дэв олгох тухай | Дугаар 177 | 1393 |
|------|--|------------|------|

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |   |            |      |
|------|---|------------|------|
| 348. | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын тухай             | Дугаар 179 | 1394 |
| 349. | Улсын гэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай | Дугаар 199 | 1395 |

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2011 оны 08 дугаар  
сарын 22-ны өдөр

Дугаар 177

Улаанбаатар  
хот

#### Төрийн захиргааны зарим албан хаагчид албан тушаалын зэрэг дэв олгох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хавсралтад дурдсан төрийн захиргааны албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын тэргүүн түшмэлийн зэрэг дэв олгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны  
8 дугаар сарын 22-ны өдрийн 177 дугаар  
зарлигийн хавсралт

**ТЭРГҮҮН ТҮШМЭЛИЙН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГ ДЭВ ОЛГОХ  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИД**

Д/д	Овог нэр	Албан тушаал	Албан тушаалын зэрэглэл	Олгох зэрэг дэв
1.	Даваахүүгийн Баттөр	Сэнгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	T3-14	Гутгаар зэрэг
2.	Содномын Энхбат	Засгийн газрын тохируулагч агентлаг-Цөмийн энергийн газрын дарга	T3-13	Дөтгөөр зэрэг
3.	Чулуунбатын Алтанхуяг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга	T3-13	Дөтгөөр зэрэг
4.	Даваагийн Баярсайхан	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга	T3-13	Дөтгөөр зэрэг
5.	Мажигийн Тунгалаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Ойн газрын дарга	T3-13	Дөтгөөр зэрэг
6.	Төгсөөгийн Батболд	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төмөр замын газрын дарга	T3-13	Дөтгөөр зэрэг

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2011 оны 6 дугаар  
сарын 8-ны өдөр

Дугаар 179

Улаанбаатар  
хот

**Хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын тухай**

Улсын Их Хурлын 2008 оны 35 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий нэгжийг төсвийн багцдаа багтаан түр хугацаагаар ажиллуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаярт зөвшөөрсүгэй.

2. Аймгийн төв, сумын сургуулиудад үдийн хоолны үйлчилгээг үе шаттайгаар нэвтрүүлэхэд шаардагдах хөрөнгийг 2012 оны төсвийн жилээс эхлэн улсын төсөвт тусгаж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд **Е.Отгонбаяр**, Сангийн сайд **С.Баярцогт** нарт тус тус даалгасугай.

3. Үдийн хоолны үйлчилгээг нэвтрүүлж байгаатай холбогдуулан хоол, хүнсний үйлчилгээний техник, технологи, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангахтай холбоотой шаардлагатай стандартуудыг боловсруулж батлуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд **С.Ламбаа**, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд **Е.Отгонбаяр** нарт даалгасугай.

4. Концессын тухай хуулийн хүрээнд Улаанбаатар хотод хоол, хүнсний загвар комбинат байгуулах уралдаант шалгаруулалтыг зарлан зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо (**Д.Сугар**)-нд даалгасугай.

5. Хоол, хүнсний комбинат байгуулахтай холбогдуулан газрын асуудлыг хот төлөвлөлтийн бодлогод тусган шийдвэрлэхийг Улаанбаатар, Дархан-Уул, Орхон аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД**

**Е.ОТГОНБАЯР**

**САНГИЙН САЙД**

**С.БАЯРЦОГТ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2011 оны 6 дугаар  
сарын 29-ний өдөр

Дугаар 199

Улаанбаатар  
хот

### **Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай**

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10.6, 11.2, 11.4, 11.5, 12, 14-20 дугаар зүйл, 21.1.2-21.1.30, 22, 24 дүгээр зүйл, 25.1.2, 25.1.3, 25.1.7-25.1.9, 26.1.6-26.1.9, 26.2, 26.3, 27.1.1, 27.1.4-27.1.6, 27.2-27.4, 28, 29 дүгээр зүйл, 30.2.2-30.2.6, 30.3-30.5 дахь хэсэг, 31-33 дугаар зүйл, 35.1.1-35.1.3, 37, 40 дүгээр зүйлд заасан тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг хэвсрэлт ёсоор баталсугай.



2. 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 7, 8 дугаар зүйлд заасны дагуу энэхүү тогтоолоор бууруулж тогтоосон тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс, бусад тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**САНГИЙН САЙД**

**С.БАЯРЦОГТ**

Засгийн газрын 2011 оны 199 дүгээр  
тогтоолын хавсралт

### **ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭ**

Нэг, Иргэний бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхэд  
хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

1.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10.6-д заасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд зөвшөөрөл, виз олгох, түүнийг бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

1.1.1. гадаадын иргэнд тус улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгоход 60 000 төгрөг;

1.1.2. суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгоход 12 000 төгрөг;

1.1.3. гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсад оршин суух үнэмлэх олгох, солиход 7200 төгрөг;

1.1.4. гадаадын иргэн, харьяалалгүй хүний тус улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгахад 36 000 төгрөг;

1.1.5. харьяалалгүй хүнд гадаадад зорчих үнэмлэх олгох, үнэмлэхийн хугацааг сунгахад 4800 төгрөг;

1.1.6. гадаадын иргэнд хувийн хэрэг хөтөлж, регистрийн дугаар элгоход 120С төгрөг;

1.1.7. гадаадын иргэн, харьяалалгүй хүний оршин суух үнэмлэхэд оршин суугаа хялгийн өөрчлөлт, бусад тэмдэглэл хийх тухай бүр 1000 төгрөг;

1.1.8. хувийн хэрэг хөтөлж, регистрийн дугаар олгосон гадаадын иргэн, харьяалалгүй хүний баримт бичигт гадаадад зорчсон тэмдэглэл хийх тухай бүр 1000 төгрөг;

1.1.9. Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгоход 1000 төгрөг;

1.1.10. гадаадын иргэний талаар тодорхойлолт гаргахад 1000 төгрөг;

1.1.11. гадаадын иргэн оршин суух болон зорчих үнэмлэхээ алдсан, үрэгдүүлсэн, гээгдүүлсэн, хүчингүй буюу ашиглах боломжгүй болгосон тохиолдолд шинээр буюу дахин олгоход 36 000 төгрөг;

1.1.12. гадаадын иргэнийг бүртгэхэд 1000 төгрөг;

1.1.13. гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгоход (хүн тус бүрээр) 1000 төгрөг;

1.1.14. гадаадын иргэн, харьяалалгүй хүнд орон нутагт явахад зөвшөөрөл олгоход (хүн тус бүрээр) 1000 төгрөг;

1.1.15. нэг удаагийн орох болон гарах-орох виз олгоход 54 000 төгрөг;

1.1.16. хоёр удаагийн орох болон гарах-орох виз олгоход 81 000 төгрөг;

1.1.17. зургаан сарын олон удаагийн виз олгоход 126 000 төгрөг;

1.1.18. зургаан сараас нэг жил хүртэлх хугацаагаар олон удаагийн виз олгоход 252 000 төгрөг;

1.1.19. дамжин өнгөрөх нэг удаагийн виз олгоход 36 000 төгрөг;

1.1.20. дамжин өнгөрөх хоёр удаагийн виз олгоход 72 000 төгрөг;



1.1.21. дамжин өнгөрөх олон удаагийн виз олгоход 96 000 төгрөг;

1.1.22. хувийн хэрэг хөтөлж, регистрийн дугаар олгосон гадаадын иргэнд нэг болон хоёр удаагийн гарах-орох виз олгоход 18 000 төгрөг;

1.1.23. нэг визэд хавсаргасан иргэдийн визийг салгах, визийг шилжүүлэн олгоход 16 000 төгрөг;

1.1.24. визийн хугацааг долоо хүртэл хоногоор сунгахад 27 000 төгрөг, дараагийн хоног тутамд 3600 төгрөг;

1.1.25. визийн ангилал өөрчлөхөд 36 000 төгрөг;

1.1.26. олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар нээн ажиллуулах зөвшөөрөл өгч, гэрчилгээ олгоход 900 000 төгрөг;

1.1.27. олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрөл өгч, гэрчилгээний хугацааг сунгахад 360 000 төгрөг;

1.1.28. олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэлийн гэрчилгээг дахин олгоход 60 000 төгрөг;

1.1.29. Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлтийг хянан шийдвэрлүүлэхэд 60 000 төгрөг.

1.2. Энэ журмын 1.1-д заасан гадаадын иргэнд үзүүлэх үйлчилгээг яаралтай буюу хилийн боомт дээр үзүүлэх тохиолдолд хураамжийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлэн хураана.

Хоёр. Консулын үйлчилгээ үзүүлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

2.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 11.2-т заасны дагуу Монгол Улсад зорчих гадаадын иргэн, харьяалалгүй хүнд виз олгоход энэ журмын 1.1-д заасан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана.

2.2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 11.4-т заасан консулын нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийн үйлчилгээнд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

2.2.1. эд хөрөнгийн бус үнэлэх боломжгүй гэрээ, хэлцэл гэрчлэхэд 18 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2.2.2. эд хөрөнгийн бус үнэлэх боломжгүй гэрээ, хэлцэлд өөрчлөлт оруулсан, хугацаа сунгасныг гэрчлэхэд 7500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2.2.3. эд хөрөнгө хөлслөх, түрээслэх гэрээ, дүрэм гэрчлэхэд 23 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2.2.4. Монгол Улсын газрын харилцаанд холбогдох гэрээнээс бусад хэлцэл (гэрээ, итгэмжлэл зэрэг)-ийг гэрчлэхэд 52 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2.2.5. баримт бичигт консулын баталгаа гаргахад 1500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2.2.6. баримт бичгийг болон баримт бичгийн хуулбарын үнэн зөвийг гэрчлэхэд хуудас тутмаас 1500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2.2.7. баримт бичгийн орчуулгыг гэрчлэхэд хуудас тутмаас 300 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2.2.8. баримт бичигт зурсан гарын үсгийг гэрчлэхэд 2500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2.2.9. гэрчлэгдсэн баримт бичгийн хуулбарыг гэрчлэхэд хуудас тутмаас 200 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2.2.10. үйлчлүүлэгчийн хүсэлтээр үндсэн материалыг шалгахад 7500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2.2.11. үл хөдлөх эд хөрөнгийн холбогдолтой баримт бичгийг гэрчлэхэд баримт бичигт тусгагдсан үнийн дүнгийн 0.06 хувиар;

2.2.12. үл хөдлөх эд хөрөнгийн гэрээг гэрчлэхэд нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхийн хувьд гэрээний үнийн дүнгээс 0.035 хувиар, бусад хүнд үнийн дүнгийн 0.055 хувиар;

2.2.13. энэ хавсралтын 2.2.1-2.2.3, 2.2.7-д зааснаас бусад гэрээ, хэлцлийг гэрчлэхэд үнийн дүнгийн 1 000 000 хүртэл төгрөгөөс 0.025 хувиар, 1 000 000 төгрөгөөс давсан хэсгээс 0.015 хувиар нэмэгдүүлж;

2.2.14. хууль тогтоомжид заасан бусад үйлчилгээ үзүүлэхэд үнийн дүнгийн 1.2 хувиар;





2.2.15. хуулийн этгээдийг үүсгэн байгуулах тухай гэрээ, дүрэм гэрчлэхэд хуудас тутмаас 240 төгрөг буюу түүнтэй тэнцэх бусад валют;

2.2.16. хуулийн этгээд үүсгэн байгуулах, татан буулгах баримт бичиг гэрчлэхэд 4 400 төгрөг буюу түүнтэй тэнцэх бусад валют;

2.2.17. хуулийн этгээд үүсгэн байгуулах, татан буулгах баримт бичигт өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасныг гэрчлэхэд 1100 төгрөг буюу түүнтэй тэнцэх бусад валют;

2.2.18. хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөн байгуулах эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг нотариатаар гэрчлэхэд 2000 төгрөг буюу түүнтэй тэнцэх бусад валют;

2.2.19. аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл болон зөвшөөрөлтэй холбогдсон баримт бичиг гэрчлэхэд 20 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх бусад валют;

2.2.20. өв залгамжлах эрх, гэрээслэл гэрчлэхэд 1100 төгрөг буюу түүнтэй тэнцэх бусад валют;

2.2.21. гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эрхийг гэрчлэхэд 1000 төгрөг буюу түүнтэй тэнцэх бусад валют.

2.3. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 11.5-д заасан өв залгамжлал, гэрээслэл, гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эд хөрөнгөөс оногдох хувиа өмчлөх эрх, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбоотой гэрээ зэрэг тодорхой үнийн дүн, төлбөрийн хэмжээ бүхий бүх төрлийн гэрээ, хэлцлийг гэрчлэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

2.3.1. 1000 хүртэл ам.доллартай тэнцэх дүнтэй бол 15 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2.3.2. 1001-10 000 ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 23 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2.3.3. 10 001-25 000 ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 30 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2.3.4. 25 001-100 000 ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 37 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2.3.5. 100 001-300 000 ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 45 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2.3.6. 300 001 болон түүнээс дээш ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 60 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2.3.7. өвлүүлэгчийн нөхөр, эхнэр, эцэг, эхээс бусад хүнд өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгоход 100 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2.3.8. аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тээврийн хэрэгслийн гэрчилгээ зэрэг үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг нотлох бүх төрлийн баримт бичгийн хуулбарыг гэрчлэхэд 7500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют.

Гурав. Тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

3.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 12.1-д заасан автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

3.1.1. автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, ашиглалтын дэвтэр олгоход 1000 төгрөг;

3.1.2. автотээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх, мэргэшсэн жолоочийн үнэмлэх олгоход 1700 төгрөг;

3.1.3. автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, ашиглалтын дэвтрийг алдаж үрэгдүүлэх, гээгдүүлэх, хүчингүй буюу ашиглах боломжгүй болгосноос дахин олгоход 20 000 төгрөг;

3.1.4. өөрөө явагч хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх олгоход 1700 төгрөг.

3.2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 12.2-г заасан автомашин, өөрөө явагч хэрэгсэл, мотоциклийн дугаар олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

3.2.1. автомашины дугаар олгоход 2200 төгрөг;

3.2.2. өөрөө явагч хэрэгсэл, чиргүүлийн улсын дугаар олгоход 1700 төгрөг;



3.2.3. мотоциклийн улсын дугаар олгоход 1100 төгрөг;

3.2.4. автомашин, өөрөө явагч хэрэгсэл, чиргүүлийн болон мотоциклийн улсын дугаарыг алдаж үрэгдүүлэх, гээгдүүлэх, хүчингүй буюу ашиглах боломжгүй болгосноос дахин олгоход 40 000 төгрөг.

3.3. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 12.3-т заасан Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авсан бол түүнийг зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа орон нутаг дахь байгууллага бүртгэхэд 1000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

3.4. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 12.4-т заасан агаарын хөлөг болон усан онгоцыг бүртгэх, агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, усан (хөлөг) онгоцыг бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

3.4.1. Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суугаа харьяалалгүй хүн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэж, үндэсний таних тэмдэг, бүртгэлийн гэрчилгээ олгоход 44 000 төгрөг;

3.4.2. гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд байгаа агаарын хөлгийг Монгол Улсын иргэний агаарын тээвэрт ашиглахаар гэрээ байгуулсан нөхцөлд улсын бүртгэлд бүртгэж үндэсний таних тэмдэг, бүртгэлийн гэрчилгээ олгоход 500 000 төгрөг;

3.4.3. энэ хавсралтын 3.4.2-т заасан гэрчилгээний хугацааг сунгахад 400 000 төгрөг;

3.4.4. агаарын хөлгийг ашиглалтаас хасах, тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулаагүй гадаадын байгууллагад болон Монгол Улсын харьяат бус бөгөөд тус улсад оршин суудаггүй хүнд худалдсан, шилжүүлсэн тохиолдолд улсын бүртгэлээс хасахад 30 000 төгрөг;

3.4.5. дотоодын усан замын тээврийн хэрэгслийг бүртгэж, дугаар, гэрчилгээ олгоход 10 000 төгрөг;

3.4.6. төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчид буюу тэдгээрийн түрээслэсэн хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэхэд 60 000 төгрөг.

Дөрөв. Сонин, сэтгүүл, радио, телевизийг улсын  
бүртгэлд бүртгэхэд хураах тэмдэгтийн  
хураамжийн хэмжээ

4.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 14.1-т заасан сонин, сэтгүүл, радио, телевизийг улсын бүртгэлд бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

4.1.1. сонин, сэтгүүлийг бүртгэж, гэрчилгээ олгоход  
22 000 төгрөг;

4.1.2. олон нийтийн болон хувийн радиог бүртгэхэд  
32 000 төгрөг;

4.1.3. олон нийтийн болон хувийн телевизийг бүртгэхэд  
100 000 төгрөг;

4.1.4. кабелийн телевизийг бүртгэхэд 120 000 төгрөг;

4.1.5. сонин, сэтгүүл, радио, телевиз, кабелийн  
телевизийн бүртгэлд өөрчлөлт орсныг бүртгэхэд 20 000 төгрөг.

Тав. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээнд  
хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

5.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15.1-д заасан хуулийн этгээдийн эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой бүртгэлийн үйл ажиллагаанд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

5.1.1. нөхөрлөл, компанийг улсын бүртгэлд бүртгэж,  
гэрчилгээ олгоход 22 000 төгрөг;

5.1.2. хоршоог бүртгэж, гэрчилгээ олгоход 13 200 төгрөг;

5.1.3. төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг  
бүртгэж, гэрчилгээ олгоход 35 000 төгрөг;

5.1.4. боловсролын байгууллагыг улсын бүртгэлд  
бүртгэж, гэрчилгээ олгоход 15 000 төгрөг;

5.1.5. эрүүл мэндийн байгууллагыг улсын бүртгэлд  
бүртгэж, гэрчилгээ олгоход 20 000 төгрөг;



5.1.6. хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоход 10 000 төгрөг;

5.1.7. хуулийн этгээдийн улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, хугацааг нь сунгахад 2200 төгрөг;

5.1.8. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг дахин олгох тохиолдолд анх хураасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг 1.5 дахин нэмэгдүүлж;

5.1.9. улсын бүртгэлийн жагсаалтаас лавлагаа олгоход 2000 төгрөг.

5.2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15.2-т заасан улс төрийн нам, шашны болон төрийн бус байгууллага, сан, холбоо, хөдөлгөөнийг бүртгэж, гэрчилгээ олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

5.2.1. улс төрийн намыг бүртгэж, гэрчилгээ олгоход 150 000 төгрөг;

5.2.2. улс төрийн намын нэр сольсныг бүртгэхэд 50 000 төгрөг;

5.2.3. шашны байгууллагыг бүртгэж, гэрчилгээ олгоход 200 000 төгрөг;

5.2.4. төрийн бус байгууллага, сан, холбоо, хөдөлгөөнийг бүртгэж, гэрчилгээ олгоход 22 000 төгрөг.

Зургаа. Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын байгууллага, түүний төлөөлөгчийн газар ажиллуулах, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

6.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 16.1-д заасан гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байгуулах, хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар ажиллуулах зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

6.1.1. салбар, төлөөлөгчийн газар, нэгж ажиллуулахад 1 100 000 төгрөг;

6.1.2. салбар, төлөөлөгчийн газрын ажиллах хугацааг сунгахад 750 000 төгрөг;

6.1.3. гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахад 750 000 төгрөг;

6.1.4. гэрчилгээний хугацааг сунгахад 75 000 төгрөг;

6.1.5. гэрчилгээг сольж олгоход анх олгоход хураасан тэмдэгтийн хураамж дээр 1.5 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр;

6.1.6. гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын гэрээ, дүрэмд орсон өөрчлөлтийг бүртгэхэд 35 000 төгрөг;

6.1.7. гадаадын хөрөнгө оруулалттай банк байгуулах зөвшөөрөл олгоход 2 800 000 төгрөг;

6.1.8. гадаадын хөрөнгө оруулалттай банкны салбар, төлөөлөгчийн газар ажиллуулах зөвшөөрөл олгоход 1 800 000 төгрөг.

Долоо. Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

7.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 17.1-д заасан банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана.

7.1.1. банк байгуулах тусгай зөвшөөрөл олгоход 1 200 000 төгрөг;

7.1.2. мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

7.1.3. зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 750 000 төгрөг;

7.1.4. төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 45 000 төгрөг;

7.1.5. өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах тусгай зөвшөөрөл олгоход 185 000 төгрөг;

7.1.6. гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах тусгай зөвшөөрөл олгоход 175 000 төгрөг;



7.1.7. үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах тусгай зөвшөөрөл олгоход 250 000 төгрөг;

7.1.8. үнэт зүйл хадгалах тусгай зөвшөөрөл олгоход 250 000 төгрөг;

7.1.9. гадаад төлбөр тооцоо хийх тусгай зөвшөөрөл олгоход 450 000 төгрөг;

7.1.10. үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах тусгай зөвшөөрөл олгоход 120 000 төгрөг;

7.1.11. санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 450 000 төгрөг;

7.1.12. зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах тусгай зөвшөөрөл олгоход 120 000 төгрөг;

7.1.13. гадаад улсад банк байгуулах зөвшөөрөл олгоход 3 200 000 төгрөг;

7.1.14. гадаад улсад банкны салбар байгуулах зөвшөөрөл олгоход 1 200 000 төгрөг.

7.1.15. энэ хавсралтын 7.1.1-7.1.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад 200 000 төгрөг;

7.1.16. хууль тогтоомжоор хориглоогүй, Монголбанкнаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 130 000 төгрөг.

Найм. Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

8.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 18.1-д заасан банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

8.1.1. арилжааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 1 000 000 төгрөг;



8.1.2. даатгалын үйл ажиллагаа эрхлэх эрхийг сэргээхэд 500 000 төгрөг;

8.1.3. давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 1 000 000 төгрөг;

8.1.4. актуарчийн эрх олгоход 350 000 төгрөг;

8.1.5. даатгагчид өөрийн салбар, төлөөлөгчийн газраа гадаад улсын нутаг дэвсгэрт нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 280 000 төгрөг;

8.1.6. даатгалын үйл ажиллагаагаа шилжүүлэх болон нэгтгэх хүсэлт гаргаж, зөвшөөрөл авахад 100 000 төгрөг;

8.1.7. гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 4 500 000 төгрөг.

8.2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 18.2-г заасан даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

8.2.1. даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгоход 45 000 төгрөг;

8.2.2. даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл олгоход 65 000 төгрөг;

8.2.3. даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрөл олгоход 85 000 төгрөг.

8.3. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 18.3-г заасан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

8.3.1. зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 300 000 төгрөг;

8.3.2. факторингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 250 000 төгрөг;

8.3.3. хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг;





8.3.4. төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 1 000 000 төгрөг;

8.3.5. төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

8.3.6. цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

8.3.7. гадаад валютын үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2 000 000 төгрөг;

8.3.8. итгэлцлийн үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

8.3.9. богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

8.3.10. үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

8.3.11. банк бус санхүүгийн байгууллагын нэр, байршлыг өөрчлөх зөвшөөрөл олгоход 10 000 төгрөг;

8.3.12. банк бус санхүүгийн байгууллагыг хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгахад Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийг олгоход 60 000 төгрөг;

8.3.13. үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгож, бүртгэхэд 30 000 төгрөг;

8.3.14. үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

8.3.15. үнэт цаасны хамтын хөрөнгө оруулалтын байгууллага байгуулах тусгай зөвшөөрөл олгоход 150 000 төгрөг;

8.3.16. үнэт цаасны хөрөнгө оруулалтын сангийн зөвшөөрөл олгоход 120 000 төгрөг;

8.3.17. андеррайтер, брокер, дилер, үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 145 000 төгрөг;

8.3.18. хөрөнгө оруулалтын менежментийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхөөр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 280 000 төгрөг;

8.3.19. банкоас бусад этгээд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

8.3.20. компанийн үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

8.3.21. хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

8.3.22. барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэл хянагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

8.3.23. хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотойгоор хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг.

Ес. Санхүү, эдийн засгийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

9.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 19.1-д заасан санхүү, эдийн засгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, эрх олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

9.1.1. нийгмийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 5 000 000 төгрөг;

9.1.2. аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

9.1.3. үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 5 500 000 төгрөг;

9.1.4. эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрөл олгоход 600 000 төгрөг;

9.1.5. хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгоход 240 000 төгрөг;

9.1.6. гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 850 000 төгрөг;



9.1.7. гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 4 500 000 төгрөг;

9.1.8. Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, эрхийн хугацаа сунгах шалгалтад тэнцсэн иргэнд мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, түүний хугацааг сунгахад 20 000 төгрөг.

Арав. Хууль зүй, дотоод хэргийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

10.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 20.1-д заасан хууль зүй, дотоод хэргийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

10.1.1. өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

10.1.2. нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 10 000 төгрөг;

10.1.3. төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2 150 000 төгрөг;

10.1.4. тамга, тэмдэг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 2 200 000 төгрөг.

Арван нэг. Байгаль орчны чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

11.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21.1.2-21.1.30-д заасан байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

11.1.1. химийн хорт болон аюултай бодис импортлох, хил дамжуулан тээвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход:

11.1.1.а. 1000 кг хүртэл 1 200 000 төгрөг;

11.1.1.б. 1001-10 000 кг 1 500 000 төгрөг;



11.1.1.в. 10 001-50 000 кг 1 800 000 төгрөг;

11.1.1.г. 50 001-100 000 кг 2 100 000 төгрөг;

11.1.1.д. 100 001-150 000 кг хүртэл 2 400 000 төгрөг;

11.1.1.е. 150 001-200 000 кг хүртэл 2 700 000 төгрөг;

11.1.1.ё. 200 001кг-аас дээш бол 3 000 000 төгрөг.

11.1.2. химийн хорт болон аюултай бодис экспортлох, устгах тусгай зөвшөөрөл олгоход 20 000 төгрөг;

11.1.3. химийн хорт болон аюултай бодис ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 25 000 төгрөг;

11.1.4. химийн хорт болон аюултай бодис худалдах тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

11.1.5. тэсэрч дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 50 000 төгрөг;

11.1.6. стандартаар хүлцэх хэмжээг нь тогтоогоогүй бохирдуулах бодис агаарт гаргах тусгай зөвшөөрөл олгоход 2 000 000 төгрөг;

11.1.7. байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

11.1.8. озон задалдаг бодисыг системээс юүлэх, цэвэрлэх, дахин цэнэглэх, засвар үйлчилгээ хийх, устгах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

11.1.9. озоны давхаргыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, байгаль орчинд ээлтэй бодис импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгоход 27 000 төгрөг;

11.1.10. озон задалдаг бодисын хольц агуулсан дараахь тоног төхөөрөмж импортлох, худалдах зөвшөөрөл олгоход:

11.1.10.а. гэр ахуйн хөргөгч, хөлдөөгч 25 000 төгрөг;

11.1.10.б. иргэн, олон нийтийн барилга, орон сууцны агааржуулагч, хөргөх хэрэгсэл 50 000 төгрөг;



11.1.10.в. үйлдвэр болон томоохон зочид буудлын хөргөх систем 100 000 төгрөг;

11.1.11. ховор амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргах нэг удаагийн зөвшөөрөл олгоход 250 000 төгрөг;

11.1.12. ховор ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргахад тухайн үеийн хуурай жингийн килограмм тутамд 3000 төгрөг, тарималжуулсан нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргахад тухайн үеийн хуурай жингийн килограмм тутамд 1000 төгрөг;

11.1.13. элбэг амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргахад 150 000 төгрөг;

11.1.14. элбэг ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргахад тухайн үеийн жингийн килограмм тутамд 1000 төгрөг;

11.1.15. нэн ховор ургамлын эд, эрхтэнийг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход килограмм тутамд:

11.1.15.а. үр 150 000 төгрөг;

11.1.15.б. навч, найлзуур, иш 30 000 төгрөг;

11.1.15.в. үндэс 120 000 төгрөг.

11.1.16. ховор ургамлыг эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход хуурай жингийн килограмм тутамд 4000 төгрөг, ховор ургамлыг гадаадад гаргах зөвшөөрөл олгоход хуурай жингийн килограмм тутамд 10 000 төгрөг, түүхий эд бүтээгдэхүүн нь 30 000 төгрөг;

11.1.17. элбэг ургамлыг гадаад улсад гаргах зөвшөөрөл олгоход 0-3 килограмм бол 3000 төгрөг, 3 килограммаас дээш бол 3000 төгрөг дээр 3 килограммаас дээш хуурай жингийн килограмм тутамд 600 төгрөг нэмж;

11.1.18.эрх бүхий байгууллагаас импортлох.

экспортлохыг зөвшөөрсөн ургамалд үзлэг шалгалт хийж хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход 0-10 килограмм бол 1000 төгрөг, 10 килограммаас дээш бол 1000 төгрөг дээр 10 килограммаас дээш килограмм тутамд 100 төгрөг нэмж;

11.1.19. 100 шоометр хүртэлх ус ашиглах зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг, 100 болон түүнээс дээш шоометр ус ашиглах зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг;

11.1.20. энэхүү хавсралтын 11.1.21-11.1.24. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41.4.13-т зааснаас бусад чиглэлээр байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх шинээр олгоход 50 000 төгрөг, сунгахад 30 000 төгрөг;

11.1.21. усны эрэл, хайгуул, судалгааны ажил явуулах, усны шинжилгээ, аудит хийх мэргэжлийн байгууллагын эрх олгоход 850 000 төгрөг, сунгахад 500 000 төгрөг;

11.1.22. усны барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, цооног өрөмдөх, худаг гаргах, сэргээн засварлах, шинэчлэх, усны барилга байгууламж барих, тоноглох, газрын хэвлийн нөхөн сэргээлт, ан агнуурын ажил эрхлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагын эрх олгоход 500 000 төгрөг, сунгахад 300 000 төгрөг;

11.1.23. ойд үндсэн ашиглалтын огтлолт, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, хуш модны самар бэлтгэх, боловсруулах, байгаль орчны төлөв байдлыг сайжруулах зорилгоор цаг агаарт зориудаар нөлөөлөх ажил эрхлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагын эрх олгоход 300 000 төгрөг, сунгахад 150 000 төгрөг;

11.1.24. эмийн болон ашигт ургамал бэлтгэх, нөхөн сэргээх чиглэлээр мэргэжлийн байгууллагын эрх олгоход 200 000 төгрөг, сунгахад 100 000 төгрөг;

11.1.25. аюултай хог хаягдлыг экспортлох, ашиглах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 20 000 төгрөг;

11.1.26. иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдах тухай конвенцийн хавсралтад орсон ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох буюу импортлох зөвшөөрөл, реэкспортлох буюу далай, тэнгисээс олборлон оруулах зөвшөөрөл, гэрчилгээ олгоход аж ахуйн нэгж, байгууллагаас 260 000 төгрөг, иргэнээс 150 000 төгрөг, бэлэг дурсгалын зориулалттай зүйл гаргах зөвшөөрөл олгоход ширхэг тутамд 50 000 төгрөг;



11.1.27. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын Амьтны аймгийн тухай хуулийн 17.3-т заасан амьтны цуглуулгыг судалгаа, шинжилгээний зориулалтаар гадаадад гаргах зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг, бусад зориулалтаар гадаадад гаргах зөвшөөрөл олгоход 450 000 төгрөг;

11.1.28. хувиргасан амьд организмыг үйлдвэрлэх эрх олгоход 3 000 000 төгрөг, судалгаа, шинжилгээний зориулалтаар хувиргасан амьд организмыг гарган авах, туршилт явуулах эрх олгоход 120 000 төгрөг;

11.1.29. хувиргасан амьд организм экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл олгоход 3 000 000 төгрөг.

Арван хоёр. Боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

12.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 22.1-д заасан боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

12.1.1. их сургууль, дээд сургууль, коллеж байгуулах тусгай зөвшөөрөл олгоход 1 000 000 төгрөг;

12.1.2. мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх богино хугацааны мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт эрхлэх зөвшөөрөл олгоход 400 000 төгрөг;

12.1.3. магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг, зөвшөөрлийг сунгахад 50 000 төгрөг;

12.1.4. дээд боловсролын байгууллага шинэ мэргэжлээр бакалаврын сургалт явуулах тусгай зөвшөөрөл олгоход 300 000 төгрөг;

12.1.5. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага байгуулах тусгай зөвшөөрөл олгоход 400 000 төгрөг;

12.1.6. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад шинэ мэргэжлээр сургалт явуулах тусгай зөвшөөрөл олгоход 150 000 төгрөг;

12.1.7. боловсролын магадлан итгэмжлэл олгоход 260 000 төгрөг;

12.1.8. дахин магадлан итгэмжлэл олгоход 85 000 төгрөг;

12.1.9. түүх, соёлын хосгүй үнэт зүйлийг бүртгэх, гэрчилгээ олгоход 2000 төгрөг;

12.1.10. улсын хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг ерөнхий боловсролын сургууль байгуулах зөвшөөрөл олгоход 65 000 төгрөг;

12.1.11. хот, суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход археологи, палеонтологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан судалгаа хийлгэж, түүнээс зөвшөөрөл олгоход 300 000 төгрөг;

12.1.12. түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход 50 000 төгрөг, шаардлагатай бол хугацааг сунгахад 30 000 төгрөг.

Арван гурав. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

13.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 24.1-д заасан нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

13.1.1. Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлүүлэхэд зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

13.1.2. зуучлах зөвшөөрлийг сунгахад 200 000 төгрөг;

13.1.3. гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахад зуучлах тусгай зөвшөөрөл олгоход 8 000 000 төгрөг;

13.1.4. Засгийн газраас гадаадын иргэнд улсын онц чухал объект гэж тогтоосон газар ажиллах зөвшөөрөл олгоход 850 000 төгрөг.





Арван дөрөв. Үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хурааж тэмдэгтийн хураамжийн хэмжээ

14.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25.1.2-25.1.3, 25.1.7-25.1.9-д заасан үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

14.1.1. аж ахуйн нэгж, байгууллага хэрэгцээнээс илүүдэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг худалдах зөвшөөрлийг мэргэжлийн байгууллагаас олгоход 50 000 төгрөг;

14.1.2. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн зөвшөөрлийг цагдаагийн байгууллагаас олгоход тухай бүр 25 000 төгрөг;

14.1.3. төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг;

14.1.4. үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг;

14.1.5. үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл олгоход 800 000 төгрөг.

Арван тав. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хурааж тэмдэгтийн хураамжийн хэмжээ

15.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 26.1.6-26.1.9-д заасан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

15.1.1. таримал ургамлын үр үйлдвэрлэх зөвшөөрөл олгоход 125 000 төгрөг;

15.1.2. малын эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл олгоход 600 000 төгрөг;

15.1.3. ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох, худалдах тусгай зөвшөөрөл олгоход 20 000 төгрөг;

15.1.4. малын гүн хөлдөөсөн үр, хөврөл үрийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, үржлийн сайжруулагч мал импортлох, экспортлох тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 200 000 төгрөг.

15.2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 26.2-т заасан үржлийн мал экспортод гаргах лиценз олгоход малын тоо толгой тутмаас дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

15.2.1. цэвэр үүлдрийн адуу 200 000 төгрөг;

15.2.2. үржлийн бусад адуу 150 000 төгрөг;

15.2.3. цэвэр үүлдрийн үржлийн үхэр 150 000 төгрөг;

15.2.4. үржлийн бусад үхэр 100 000 төгрөг;

15.2.5. цэвэр үүлдрийн гахай 18 000 төгрөг;

15.2.6. хонь 60 000 төгрөг;

15.2.7. ямаа 60 000 төгрөг;

15.2.8. тэмээ 300 000 төгрөг.

15.3. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 26.3-т заасан малын гүн хөлдөөсөн үр, хөврөл үр, бичил биетний өсгөөр экспортод гаргахад дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

15.3.1. үржлийн малын гүн хөлдөөсөн үр, хөврөл үр 25 000 төгрөг;

15.3.2. мал эмнэлгийн зориулалттай вакцин, бусад бичил биетний өсгөөр 130 000 төгрөг.

Арван зургаа. Эрүүл мэндийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

16.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 27.1.1, 27.1.4-27.1.6-д заасан эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:



16.1.1. эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тонсг төхөөрөмж, протез, ортопед үйлдвэрлэх, худалдах, импортлох тусгай зөвшөөрөл олгоход 110 000 төгрөг;

16.1.2. эмнэлгийн тусламж үзүүлэх бүх төрлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 400 000 төгрөг;

16.1.3. биологийн идэвхт үйлчилгээтэй бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

16.1.4. өвчнийг оношлох, эмчлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх шинэ арга турших, нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход 20 000 төгрөг.

16.2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 27.2-т заасан өвчин үүсгэгч нян, түүний хорыг өсгөвөрлөх, үржүүлэх, хадгалах, нөөцлөх, тээвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

16.2.1. импортын лиценз олгоход 12 500 төгрөг;

16.2.2. экспортын лиценз олгоход 12 500 төгрөг.

16.3. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 27.3-т заасан ахуйн шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 50 000 төгрөг хураана.

16.4. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 27.4-т заасан эмнэлгийн мэргэжилтэнд эмчлэх, сувилах, эм барих зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

16.4.1. анагаах ухааны боловсрол олгох тусгай зөвшөөрөл бүхий сургууль төгссөн их эмчид хоёр жилийн хугацаатай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 10 000 төгрөг;

16.4.2. мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт өгч тэнцсэн эм зүйч, эм найруулагч, хүний бага эмч, эх баригч, сувилагч болон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 27.4.1-д заасан зөвшөөрлөөр хоёр жил ажилласан эмчид 5 жилийн хугацаатай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 5000 төгрөг;

16.4.3. анагаах ухааны болон эм зүй, сувилахуйн боловсрол эзэмшсэн, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн гадаадын иргэн,

харьяалаггүй хүнд эмчлэх, эм барих, сувилахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 5 хүртэл жилийн хугацаагаар олгоход 120 000 төгрөг.

Арван долоо. Барилга, хот байгуулалтын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

17.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 28.1-д заасан барилга, хот байгуулалтын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

17.1.1. барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

17.1.2. цамхаг, тулгуур, түшиц хана, яндан, антенна, цутгамал болон угсармал барилга, газар дээрх ба доорхи тусгай зориулалтын барилга, инженерийн болон цахилгааны гол магистрал шугам, хий болон нефтийн агуулах шатахуун түгээх байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралт, усны барилга байгууламжийн ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2 500 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 2 000 000 төгрөг;

17.1.3. барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

17.1.4. өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 350 000 төгрөг;

17.1.5. нийтийн аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 1 000 000 төгрөг;

17.1.6. цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30 метрээс дээш өндөр, 60 метрээс дээш алгасагттай байгууламж, 16-гаас дээш давхар барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх, тухайн барилга байгууламжид зөвшөөрөл олгоход 2 400 000 төгрөг;

17.1.7. геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

17.1.8. хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн төсөл, бүс нутгийн хөгжлийн төсөл, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, үе шатны бусад зураг төслийг боловсруулах мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл олгоход 900 000 төгрөг;



17.1.9. барилгын засвар үйлчилгээ, орчны тохижилт, түүх, соёлын барилга, мод ба өрөгт бүтээцэн барилга, барилгын өргөтгөл шилжүүлэл, барилгын доторхи инженер, цахилгаан хангамж, гал, холбоо дохиоллын, ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 200 000 төгрөг.

Арван найм. Зам, тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

18.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 29.1-д заасан зам, тээвэр, аялал, жуулчлалын чиглэлээр эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

18.1.1. төмөр замын суурь бүтэц барих, ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 5 000 000 төгрөг;

18.1.2. төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах тусгай зөвшөөрөл олгоход 5 000 000 төгрөг;

18.1.3. төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 16 000 000 төгрөг;

18.1.4. хатуу хучилттай авто зам барих тусгай зөвшөөрөл олгоход 1 000 000 төгрөг;

18.1.5. энэ хэвсгалтын 18.1.4-т зааснаас бусад авто зам, замын байгууламж барих, тусгай зөвшөөрөл олгоход ангилал тус бүр нь 300 000 төгрөг, авто зам, гүүр засварлах, арчлах зөвшөөрөл олгоход 300 000 төгрөг;

18.1.6. авто тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 280 000 төгрөг;

18.1.7. агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 150 000 төгрөг;

18.1.8. нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгоход 40 000 төгрөг;

18.1.9. усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр:



18.1.9.а. дунд оврын хөлөг онгоцонд 350 000 төгрөг;

18.1.9.б. бага оврын усан онгоцонд 200 000 төгрөг;

18.1.9.в. жижиг оврын моторт завинд 100 000 төгрөг.

18.1.10. тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 1 450 000 төгрөг;

18.1.11. байнгын үйл ажиллагаатай аэродромыг улсын бүртгэлд бүртгэхэд 44 000 төгрөг.

Арван ес. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

19.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 30.2.2-30.2.6-д заасан харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

19.1.1. интернет, өгөгдөл дамжуулах үйлчилгээ эрхлэхэд 100 000 төгрөг;

19.1.2. телевиз, радиогийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэхэд 80 000 төгрөг;

19.1.3. шуудангийн үйлчилгээ эрхлэхэд 50 000 төгрөг;

19.1.4. харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэхэд 50 000 төгрөг;

19.1.5. дамжуулан хүргэх, нэмэлт үйлчилгээ эрхлэхэд 30 000 төгрөг.

19.2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 30.3-г заасан контентийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

19.2.1. телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхэд нийслэлд 50 000 төгрөг, аймагт 20 000 төгрөг;

19.2.2. радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхэд нийслэлд 40 000 төгрөг, аймагт 15 000 төгрөг;



19.2.3. кабелийн сувгийн үйлчилгээ эрхлэхэд нийслэлд 50 000 төгрөг, аймагт 20 000 төгрөг;

19.2.4. тусгай дугаар ашигласан мэдээлэл, лавлагааны үйлчилгээ эрхлэхэд 20 000 төгрөг;

19.2.5. контент агрегаторын үйлчилгээ эрхлэхэд 50 000 төгрөг.

19.3. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 30.4-т заасан бүртгэлийн гэрчилгээ олгоход 20 000 төгрөг;

19.4. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 30.5-д заасан радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 25 000 төгрөг.

Хорь. Хэмжил зүйн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

20.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 31.1-д заасан хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг.

Хорин нэг. Мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

21.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 32.1-д заасан Монгол Улсын хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд экспортын болон импортын гэрчилгээ, импортын мэдэгдэл олгоход 10 000 төгрөг.

Хорин хоёр. Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

22.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33.1-д заасан гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

22.1.1. галын аюултай (газрын тосны бүтээгдэхүүн, шатамхай хий, шянгэн) болон тэсэрч дэлбэрэх бодис, материал хадгалах, ашиглахад галын аюулгүй байдлын зөвшөөрөл олгоход:

22.1.1.а. нефтийн бүтээгдэхүүн, шатдаг хийн агуулахад:



№	Нефтийн бүтээгдэхүүн, шатдаг хийн агуулахын багтаамж (куб,м)	Хураамжийн хэмжээ (төгрөгөөр)
1	2000 болон түүнээс доош	300 000
2	2001-10 000	500 000
3	10 001-20 000	700 000
4	20 001-50 000	800 000
5	50 001-ээс дээш	1 000 000

22.1.1.б. шатахуун болон хий түгээх станцад 100 000 төгрөг;

22.1.1.в. шатдаг хий жижиглэн борлуулахад 12 500 төгрөг;

22.1.1.г. тэсэрч дэлбэрэх бодис, материал ашиглахад 300 000 төгрөг.

22.1.2. барилга байгууламжийг шинээр барих зураг төсөлд хяналт хийн зөвшөөрөл олгоход:

№	Барилга байгууламжийн багтаамж (куб метр)	Хураамжийн хэмжээ (төгрөгөөр)
1	3000 хүртэл	50 000
2	3001-10 000	100 000
3	10 001-ээс дээш	150 000

22.1.3. барилгын өргөтгөл болон хийц бүтээц, цахилгааны эх үүсвэр, шугам сүлжээний зураг төсөлд хяналт хийн зөвшөөрөл олгоход 50 000 төгрөг;

22.1.4. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 16.1.7-д заасны дагуу ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргахад 12 500 төгрөг.

Хорин гурав. Аймаг, нийслэлийн Засаг даргаас тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

23.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.1.1-35.1.3-т заасан аймаг, нийслэлийн Засаг даргаас тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

23.1.1. улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын





хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагаас бусад эрүүл мэндийн байгууллага байгуулах зөвшөөрлийг олгоход 400 000 төгрөг;

23.1.2. гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдээс бусад этгээдэд эмчилгээний гоо заслын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг олгоход 500 000 төгрөг;

23.1.3. ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах зөвшөөрөл олгоход 250 000 төгрөг.

Хорин дөрөв. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах зөвшөөрөл олгоход хураах хураамжийн хэмжээ.

24.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 37.1-д заасан оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах иргэн, хуулийн этгээдийг шалгаруулж, зөвшөөрөл олгоход 100 000 төгрөгийн хураамж хураана.

Хорин тав. Баримт бичиг баталгаажуулж, "Апостиль" гэрчилгээ олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

25.1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 40.1-д заасан гадаадын албан ёсны баримт бичгийг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенцийн гишүүн улсад хэрэглэгдэх дотоодын албан ёсны баримт бичгийг төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулж, "Апостиль" гэрчилгээ олгоход 20 000 төгрөгийн хураамж хураана.

**Ханг:**

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци.

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin\_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 2

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсгээс хэвлэн  
Утас 329487